

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ

Б.Санжмятав*

Дэлхийн эдийн засаг эрчимтэй хөгжиж, үйлдвэрлэл өсөхийн хирээр байгалийн эрдэс баялагийн хэрэглээ нэмэгдэж, улмаар нөөц нь ховордох болсон. Өнөөдөр хүн төрөлхөтний стратегийн хамгийн чухал түүхий эд болох газрын тос, байгалийн хийн нөөц өнөөдрийн хэмжээгээр хэрэглэхэд 40 жилд хүрэлцэхээр байгаа бол, газрын ховор элемент, зарим металл одоо дэлхийн хэмжээнд ховордож эхэлсэн байна¹. Эдийн засагч, судлаачдын үзэж байгаагаар өнөөдөр дэлхий дээр 30 гаруй оронд л эрдэс түүхий эдийн нэлээд нөөц үлдсэн ажээ. Ийнхүү байгалийн нөөц баялагтай үлдсэн орны нэг нь Монгол Улс болно. Хятадын Монголыг судлах хүрээлэнгийн судлаачдын үзэж байгаагаар Монгол Улс байгалийн баялагийнхаа хэмжээгээр дэлхийд 29 дугаар байранд орж байгаа гэж тооцоолжээ².

Өнөөдөр Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбар нь хөгжлийн гол зүтгүүр болж, төсвийн орлогын гол эх үүсвэр болж байгаа нь бодитой болно. Уул уурхайн салбар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70, экспортын бүтээгдэхүүний 80 орчим хувийг гаргаж байна. Дээрх үзүүлэлтүүд шинэ орд газрууд ашиглалтад орохын хирээр нэмэгдэгдэх нь тодорхой байна.

Монгол Улсад орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь уул уурхайн салбарт байжээ. Монголд орж ирж байгаа ГШХО 2010 онд 1,026 тэрбум ам. доллар, 2011 онд 4,9 тэрбум ам. доллар, 2012 онд 3,9 тэрбум ам. доллар байсан байна. ГШХО 2012 онд өмнөх оныхоос буурсан нь Оюу толгойн хөрөнгө оруулалтын эхний ээлж дуусч, олборлох үйлдвэр баригдаж дууссантай холбоотой. ЭЗХЯ-наас гаргасан 2012 оны мэдээгээр ГШХО-ын 73.9 хувь нь геологи хайгуул, уул уурхайн салбарт байжээ. Өнөөдөр ГШХО-ттай компаниуд ДНБ-ний 5 хувийг үйлдвэрлэж, татварын 50 хувийг төлж байна³. Дээрх тоо нь гадаадын хөрөнгө оруулагчид Монголд уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, олборлосон баялгаа экспортолж ашгаа шууд авч байгааг хандлагыг харуулж байна.

Монголд ГШХО эрх зүйн орчин ч таатай байгаа гэж хэлэх үндэстэй. Дэлхийн банкны Бизнесийн орчны судалгаа(Doing Business report 2013)-

* МУИС, ОУХС-ийн багш, доктор (Ph.D), дэд проф

1. Key World Energy Statistics, IEA, 2010, p 15

2. Хөгжилт. Хятад, Монголын хамтын ажиллагааны харилцааны суурь нөхцөл, анализ, Монгол, Хятадын уул уурхайн хамтын ажиллагаа сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, УБ, 2013

3. UNCTAD report, "Investment Policy review", FDI data 2011

гаар Монгол Улс 2013 онд дэлхийн 127 орноос 76-д орсон нь өмнөх оныхоос 12 байраар ахисан байна. Монгол Улсын Засгийн газар ГШХО-ын бодлого, эрх зүйн орчныг тогтвортой байлгах, тэдгээрийг илүү боловсронгуй болгох үүднээс 2013 онд ЮНКТАД-тай хамтран “Хөрөнгө оруулалтын бодлогын хяналт”-ын тухай тусгай илтгэл гаргаад байна. Засгийн газар энэхүү илтгэлийг боловсруулах хүрээнд ГШХО-ын бодлого, хууль эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийн явцад үнэлгээ өгч, гарч байгаа зарим алдааг засах зорилт тавьсан юм.

Монгол Улсын Их хурал 2013 оны намар Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталж, 1993 онд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын хууль, 2012 онд батлагдсан Стратегийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид оруулсан Гадаадын шууд хөрөнгө оруулалтын зохицуулалтын тухай хуулийг хүчингүй болгосон. Энэхүү хуулиар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг ялгахгүй болгож, ГШХО-ын эрх зүйн орчинг илүү таатай болгох, бодлогын тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авсан болно. Бусад хууль эрх зүйн баримт бичигт Ашигт малтмалын тухай хууль, газрын тухай хууль, байгаль орчны багц хуулиуд чухал үүрэгтэй байна.

Монгол Улсын Засгийн газраас ГШХО-ыг татах, хөрөнгө оруулах орчныг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч байгаа боловч судалгаа муутай, нэг талд үйлчилсэн, хөрөнгө оруулагчдад тал зассан хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, Олон улсын эрх зүйд төрийн дархан эрх гэсэн ойлголт байдаг. Энэхүү эрх зүйн хэмжээний хүрээнд аливаа тусгаар улсын нутаг дэвсгэрт зөвхөн тухайн улсын төр, засгийн зүгээс тогтоосон, эсхүл түүний зүгээс хүлээн зөвшөөрсөн нэгдэн орсон олон улсын гэрээний хэм хэмжээ л үйлчлэх ёстой. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нутагт дэвсгэрт өөр улсын стандарт, эрх зүйн хэм хэмжээ үйлчлэх учиргүй. Монгол Улсын Үндсэн хуулийн 10.3-д олон улсын гэрээний үйлчлэх хэм хэмжээг тодорхойлохдоо “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”⁴ гэжээ. Гэтэл гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд санхүүгээ хөтлөн явуулах, мөнгөө байршуулах, худалдан авалт хийх зэрэг ажиллагааг явуулахдаа гадаад орны стандарт, нормыг олонтаа мөрдүүлж байгаа нь олон улсын хамтын ажиллагааны жишигт нийцэхгүй байна. Энэ байдал нь төр, засгийн зүгээс гадаадын хөрөнгө оруулалтад хяналт тавих, мөн түүнийг үндэсний эрх ашгийн үүднээс бодлогоор удирдах, байгалийн нөөц баялгийн борлуулалтаас орох орлогоос хувь хүртэх бололцоог багасгаж байна. Энэ талаар Монгол Улсын Иргэний хуулийн 544.2-д гадаад улсын хуулийн этгээд Монгол Улсад аливаа хэлцэл хийхдээ

4. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдэлэл, 1992, №1,

хуулиар тогтоогоогүй хязгаарлалтыг хэрэглэж болохгүй⁵ гэж заасан нь ч бий.

Гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой өөр нэг томоохон асуудал бол тэдэнд хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэх явдал нэлээд түгээмэл байна. Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжиж, улс оронд хөрөнгө мөнгө дутагдаж байх үед Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд зарим хөнгөлөлтийг үзүүлж байсан боловч 1997 онд ДХБ-д элсэж, бизнесийн харилцаанд ДХБ-ын заавал биелүүлэх үүрэгтэй эрх зүйн орчинд орсноор дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг ялгаварлан гадуурхахгүй байх эрх зүйн орчин бүрдсэн. Гэвч эрх баригчид үндэсний эрх ашиг, олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ үл харгалзан Үндэстэн дамнасан компаниудад олон тооны хөнгөлөлт, чөлөөлөлт олгосоор байгаа нь эрх зүйн хувьд хууль бус болж байгаа. Энэ байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимтай ч зөрчилдөж байгаа болно. Тухайлбал Үндсэн хуулийн 10 дугаар бүлгийн 2-т Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ⁶, 4-т Монгол Улсын Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэж заажээ. Энэ байдлыг уул уурхайн хэдэн жишээн дээр авч үзье.

Засгийн газар орд газрыг ашиглах асуудлаар үндэстэн дамнасан компаниудтай хэлэлцээ хийхэд өөрөө бэлэн биш, тэгээд хэлэлцээ хийх үндэсний багаа бэлтгээгүй байхад хэдэн сайд нар хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцэл байгуулахдаа үндсэндээ нөгөө талын эрх ашгийг хамгаалж ирсэн нь олон жишээн дээр тодорхой харагддаг. Эл байдал нь Оюу Толгой, Бороогийн алтны орд, Таван Толгойн нүүрсний зэрэг ордуудыг ашиглах талаар байгуулсан гэрээг уншиж байхад эл байдал тодорхой харагддаг. Ийнхүү Монгол Улсаас олон улсын хэмжээнд авсан үүргээ зөрчиж байгуулсан зарим жишээг дурдвал:

Засгийн газраас Бороогийн алтны орд, Оюу толгойн орд, Таван толгойн нүүрсний ордыг ашиглах талаар Үндэстэн дамнасан компаниудтай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ, тогтвортой байдлын гэрээнд олон тооны хөнгөлөлт, чөлөөлөлт олгосон. Гэтэл Монгол улс 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-д элсэхдээ гадаадын хөрөнгө оруулалтад экспортын татаас олгохгүй байх, тухайн үед гадаадын хөрөнгө оруулалтын хуулиар олгож байсан хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг хүчингүй болгох үүрэг⁷ авсан байдаг. Энэ талаар Монгол Улсыг ДХБ-д элсүүлэх асуудлаарх Ажлын хэсгийн илтгэлийн 22 дугаар зүйлд дурдахдаа, гадаадын хөрөнгө

5. Олон улсын хувийн эрх зүй/баримт бичгийн эмхэтгэл/, МУ-ын Иргэний хууль, Төрийн мэдээлэл, 2002, №7

6. Төрийн мэдээлэл, 1992, №1,

7. ДХБ-ыг байгуулах 1994 оны Марракешийн хэлэлцээрийн 2.2-д “Гишүүн орнууд олон талт худалдааны хэлэлцээрүүдийг заавал дагаж мөрдөнө” гэж заасан. Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны дүнд байгуулагдсан эрх зүйн баримт бичгүүд, УБ, 2000 он, х7

оруулалтын хуулиар тогтоосон хөнгөлөлтүүд нь ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийг 1 дүгээр хавсралтад буй “Хялбаршуулсан жагсаалт”-ын дагуу экспортын татаас гэж тооцогдохыг Монголын төлөөлөгч хүлээн зөвшөөрч, тэдгээрийг 2002 оны 12 дугаар сарын 31-ний наана цуцлах, мөн дээрх татаасыг шинэчлэхгүй байх үүргийг Ажлын хэсгийн хуралдаан дээр авсан болохыг тэмдэглэжээ⁸. Энэ хүрээнд экспортын татаас олгохгүй байх үүрэг хүлээсэн. ДХБ-ыг эрх зүйн орчин нь гишүүн орнуудад заавал биелүүлэх үүрэгтэй, мөн Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулинд “олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасны дагуу дотоодын бизнесийн хэлцэл нь Олон улсын гэрээ, конвенцээс давуу эрх эдлэхгүй бөгөөд Олон улсын гэрээний заалтуудыг даган мөрдөх учиртай. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар бүлгийн 2-т Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэж заасныг өмнө тэмдэглэсэн байгаа.

Хөрөнгө оруулалтын болон тогтвортой байдлын гэрээ нь оруулсан хөрөнгийн баталгааг хангах, оруулсан хөрөнгө, олсон ашгаа эх орон руугаа чөлөөтэй шилжүүлэх, хөрөнгө удирдан зарцуулах эрх зүйн баталгааг хангах үүрэгтэй болохоос хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх зорилгогүй байх ёстой. Гэтэл Монгол улсын Засгийн газраас анх “Бороо гоулд” ХХК-тай байгуулсан гэрээнд олон улсын хэмжээнд авсан, заавал биелүүлэх дээрх үүргийг зөрчсөн. Засгийн газар Бороо гоулд ХХК-тай 1998 оны 7 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан “Тогтвортой байдлын гэрээ”-гээр тус компанийг аж ахуйн нэгжийн албан татварыг эхний гурван жил 100 хувь чөлөөлж, дараагийн гурван жилд 50 хувь чөлөөлөх, импортын гаалийн татвар, экспортын гаалийн татвар тэг байхаар тогтоожээ. Гэтэл уг гэрээнд 2000 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр дээрх хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг баталгаажуулахын зэрэгцээ бусад бүх татваруудыг царцааж, гэрээ байгуулах үеийнхээр тогтвортой байлгахар өөрчилжээ. Энэхүү өөрчлөлтийн хор уршигаар бүх төрлийн татвар, төлбөр, хураамжуудыг 1998 онд үйлчилж байсан хэмжээгээр төлж байсан нь хууль бус болсон бөгөөд үндэсний хэмжээнд ихээхэн хохирол учруулсан байна. Бороо гоулд ХХК нь олборлосон алтаа Монгол банкинд тушаахгүйгээр шууд Канадад гаргаж байснаас НӨАТ-аас зугатаж, гэнэтийн ашгийн 68 хувийн татварыг төлөөгүй, ашгийн татвараа эхний хэдэн жилд Канадад төлсөн нь Монгол Улсын авах ёстой байсан асар их хөрөнгө хууль бусаар улсын төсөвт ороогүй. Засгийн газар газрын тосны хайгуул, ашиглалтын талаар байгуулсан гэрээнүүдэд ч дээрхтэй адил заалтууд орсон. Тогтвортой байдлын гэрээтэй Цайрт Минералс ХХК нь мөн гэнэтийн ашгийн 68

8. ДХБ-д Монгол Улс нэгдэн орох асуудлаарх Ажлын хэсгийн илтгэл, х37, ДБ дахь Монгол улс, УБ, 2003, www.wto.org

хувийн татвар төлөөгүй. Гэтэл Эрдэнэт ХК, Монголросцветмет ХК дээрх татваруудаас чөлөөлөгдөөгүй. Ийнхүү ДХБ-ын суурь зарчмуудын нэг болох компаниудыг бизнест өөр хооронд нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчим давхар зөрчигдсөн.

Монгол Улсын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулагчтай үндэсний эрх ашигт нийцээгүй гэрээ байгуулсан дараагийн томоохон тохиолдол нь Оюу Толгойн ордыг ашиглах гэрээ болно. УИХ-ын 2008 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор Оюу Толгой төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үндсэн зарчим, чиглэлийг тодорхойлсон бол, УИХ-ын 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолоор Оюу Толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах эрхийг Засгийн газарт олгосон юм. Монгол Улсын Засгийн газрын хооронд 5 жилийн туршид хийсэн хэлэлцээний үр дүнд Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ 2009 онд байгуулагдсан.

Засгийн газар Оюу Толгойн гэрээнд Монгол Улсын хувьд хэрэгжих ёсгүй олон заалтуудыг оруулаад мөрдөж байгаа нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээний заалтууд, хүлээсэн үүргийг зөрчиж байна. Уг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10.4-д Үндсэн хууль, бусад хуульд харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэсэн заалт байдаг. Гэтэл Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний 2.1 дүгээр заалтад Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 3.2.2, Ашигт малтмалын тухай хуулийн 29.1.1 дэх хэсгийг үндэслэн нийт 24 татвар төлөхөөс дараах 8 төрлийн татварыг өсгөхгүй тогтворжуулахаар тусгасан байна. Үүнд:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
2. Гаалийн албан татвар
3. Нэмэгдсэн өртгийн албан татвар
4. Онцгой албан татвар
5. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (роялти)
6. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
7. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
8. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн дагуу 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болох зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар болно.

ДХБ-ын Татаас болон Саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд Татааст, засгийн газар, эсхүл засгийн газрын байгууллагаас үзүүлж байгаа санхүүгийн туслалцаа, тухайлбал засгийн

газраас мөнгөн хөрөнгийг шууд шилжүүлэх, шилжүүлэх үүрэг хүлээсэн, засгийн газар хураах ёстой орлогоосоо татгалзах, хурааж авахгүй байх, нийтлэг дэд бүтцээс бусад бараа, үйлчилгээгээр хангах, эсхүл бараа худалдан авах, аль нэг сангийн тогтолцоонд төлбөр хийж байгаа, эсхүл засгийн газрын гүйцэтгэдэг үүргийг хэрэг дээрээ ялгаагүй нөхцлөөр хувийн байгууллагаар гүйцэтгүүлэх, ТХЕХ-ын 16 дугаар зүйлийн утгаар орлого, үнийг дэмжих явдлыг оруулахаар тогтоожээ⁹. Экспортын татааст бүтээгдэхүүнээ экспортод гаргаж байгаа компанид үзүүлэх бүх төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг оруулан тооцдог байна. Энэ утгаар авч үзвэл уул уурхайн компаниуд нь татаастай бензин нийлүүлж байгаа ч бас хууль бус болно.

Ийнхүү Засгийн газраас Оюу Толгой ХХК-д олгосон хөнгөлөлт, чөлөөлөлтүүд нь ДХБ-ын эрх зүйн хүрээнд хүлээсэн **нэгдүгээрт**, гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай компаниудыг ялгаварлан гадуурхахгүй байх, **хоёрдугаарт**, ГШХО-д үзүүлж байсан хөнгөлөлт, чөлөөлөлтөө 2002 оны эцэст хүчингүй болгосон байх, **гуравдугаарт** экспортын татаас олгохгүй байх гэсэн 3 үүргийг давхар зөрчиж байна.¹⁰

Таван Толгойн ордыг ашиглах талаар Монголын Эрдэнэс Таван толгой, Хятадын Чалко компанийн хооронд байгуулсан гэрээ ч олон улсын эрх зүйг олон чиглэлээр зөрчиж байгуулагдсан. Тухайлбал Таван Толгойн нүүрсийг борлуулах үнэ нь демпингийн үнэ болсон. Гэрээг байгуулах үед дэлхийн нүүрсний зах зээл дээр 1 тн коксждог нүүрс дунджаар 100 ам. долларын үнэтэй байсан бол талууд 1тн нүүрсийг 70 ам. доллараар буюу түүнээс бага үнээр авч, өгөлцөхөөр тохиролцсон байна. Монголын нүүрсийг Хятадад 50-70 ам. доллараар борлуулах үнэ нь Монгол, Хятадын дотоод зах зээл дээр нүүрс борлуулах үнээс ч доогуур байгаа юм. ДХБ-ын Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийн 2.1-д демпинг гэж бараа бусад орны зах зээлд хэвийн өртгөөсөө доогуур үнээр нэвтрэн орж байгааг хэлэх буюу тухайн барааны нэг орноос нөгөө орон руу нийлүүлэгдэж буй экспортын үнэ нь экспортлогч орон дахь хэрэглээнд зориулагдсан ижил барааны ердийн худалдаан дахь харьцуулах үнээс доогуур байна гэж тодорхойлсон¹¹ байна. Одоо Эрдэнэс Таван Толгой компани нүүрсээ Хятадын Чалко компанид 50 хүрэхгүй ам. доллараар, бараг өөрийн өртгөөс бага үнээр борлуулж байгаа нь дээрх эрх зүйн хэм хэмжээг зөрчиж байгаа болно.

9. Resultats des negociations commerciales multilaterals du cycle d'Uruguay, Geneve, 1994, p 279

10. Б.Санжмятав - Монгол Улсын эдийн Засгийн гадаад хамтын ажиллагааны бодлогын тулгамдсан асуудлууд, х144, УБ, 2012,

11. Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээр 1994-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр, Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны дүнд байгуулагдсан эрх зүйн баримт бичгүүд, УБ, 2000 он, х168

Уул уурхайн компаниуд нь хэрэглэж байгаа түлш, шатахууныг татаастай үнээр худалдан авч, мөн бүтээгдэхүүнээ экспортод гаргаад түүнийг олборлоход хэрэглэсэн бүтээгдэхүүнд шингэсэн зарим татварыг буцаан авч байгаа нь мөн л ДХБ-ын эрх зүйн орчин, шударга өрсөлдөөний хүрээнд хүлээсэн үүрэгтэй зөрчилдөж байгаа юм.

Байгалийн баялаг нь тухайн улс, ард түмний гурван үеийн нийтийн өмч, баялаг болж байдаг. Өөрөөр хэлбэл түрүүчийн үеийнхний үлдээж өгсөн, одоогийн болон ирээдүйн үеийнхний нийтийн өмч гэсэн үг юм. НҮБ-ын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пактын 1 дүгээр зүйлийн 2-т улс түмнүүд олон улсын хамтын ажиллагаанд оролцоходоо үндэснийхээ баялгийг харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр, олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд чөлөөтэйгээр захиран зарцуулах эрхтэй¹² гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуульд ч байгалийн баялаг нь ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гэж эрх зүйн орчныг нь тодорхойлжээ. Тийм учраас байгалийн баялгийг нэгэн үеийнхэн ашиглаад дуусах бус, харин зарим хэсгийг нь дараагийн үеийнхэнд үлдээх, баялгийг ашигласнаас олох орлогын нэг хэсгийг дараагийн үеийнхэнд үлдээх буюу тэдний хэрэглэх эдийн засгийн дэд бүтцийг бүтээхэд зарцуулдаг уламжлал бий. Эл утгаар байгалийн баялгийг авч үзвэл үндэстний эрх ашгийн үүднээс маш нарийн бодлогоор зохицуулах шаардлагатай байдаг байна. Гэтэл бид өнөөдөр үндэстнийхээ баялагт өөриймсөг сэтгэлээр хандахгүй, түүнийг ашиглах бодлогын болон эрх зүйн орчин нь эрх баригчдын сонирхлыг даган өөрчлөгдөх болсон нь тийм ч сайн зүйл биш бололтой. Монгол Улсын Ашигт малтмалын хуулиар улсын төсвийн хөрөнгөөр хайгууль хийж, ордыг нь илрүүлсэн стратегийн томоохон ордуудад улсын оролцоог хангахаар заасан боловч манай стратегийн батлагдсан ордуудын хагас нь гадаад, дотоодын томоохон компанийн мэдэлд нэг мэдэхэд шилжсэн баримт байна. Эл байдал нь төрийн хуулийг зөрчсөн, ард түмний өмч, төрийн хамгаалалтад байх ёстой баялаг бусдын гарт үнэгүй очсон болохыг гэрчилж байна.

Улс орнууд, ялангуяа эдийн засаг нь байгалийн баялгаас ихээхэн хамааралтай орнууд байгалийн баялгаа урт хугацаанд хөгжлийг тэтгэх зүтгүүр байлгахын тулд зарим төрлийн ордыг ашиглах явдлыг бодлогоор хойшлуулан нөөж үлдээх, жилд олборлох хэмжээг тогтоож өгөх, өөрсдийн чадах хэмжээнд ордыг дотоодын аж ахуйн нэгжүүдээр эзэмшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн ажилладаг байна. Өнөөдөр байгалийн баялгийн хэмжээ хязгаарлагдмал, тэдгээрийн дийлэнх нөөц дэлхийн хэмжээнд багассан, байгалийн баялгийг олборлох техник, технологи, чадавхи цөөн үндэстэн дамнасан компанийн гарт төвлөрсөн байгаа нөхцөлд төрийн

12. Pacte internationale relative aux droits économiques, sociaux et culturels, adopte par l'Assemblée Generale des NU, le 3 janvier 1966, p 3 www.un.org

маш нарийн, алсыг харсан бодлого, эрх зүйн орчин шаардлагатай байна.

Дээрхээс дүгнэж, Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын зэрэг, сөрөг туршлагыг Оюу Толгойн жишээн дээр авч үзвэл:

Оюу Толгойн сөрөг туршлага:

- Нөөцийг тодорхойлох, хайгуулын ажилд хөрөнгө оруулалт хийгээгүй;
- Олон улсын хэмжээний томоохон төслөөр хэлэлцээ хийх үндэсний багаа бүрдүүлээгүй, хэлэлцээний бэлтгэлийг муу хангасан;
- Хөрөнгө оруулалт, тогтвортой байдлын гэрээний хэлэлцээг мэргэжлийн түвшинд хийгээгүй;
- Гэрээг байгуулахын тулд судалгаа, үндэслэл муутайгаар Монгол Улсын дотоодын олон хуулинд өөрчлөлт оруулсан;
- Монгол Улсын хууль, Олон улсын эрх зүйгээр тогтоосон хэм хэмжээг зөрчиж, хөрөнгө оруулагчаа илт ашигтай гэрээ байгуулсан;
- Хөрөнгө оруулж, хувьцаа эзэмшигч болсны хувьд эрхээ хэрэгжүүлэх шалгалтын механизмыг сул бүрдүүлсэн;
- Нөөцийг эцэслэн тогтоож нэг мөр болгоогүйгээр хэлэлцээр байгуулсан;
- Төслийг зээлээр хэрэгжүүлэх болсон нь Монголын талд гарч болох ашгийн хэмжээг багасгасан;
- Гэрээнд ажиллагсдын нийгмийн асуудлыг сул тусгасан;

Оюу Толгойн эерэг туршлага:

- Дэлхийн хэмжээний тэргүүний техник, технологи, стандартыг нэвтрүүлсэн;
- Дотоодын бизнест өсөлт, тэргүүний менежментийг нэвтрүүлсэн;
- Дотооддоо боловсон хүчин бэлтгэх боломжтой болсон;
- Орон нутгийн хөгжилд нааштай нөлөөлсөн;
- Дэд бүтэц хөгжихөд түлхэц болсон;

Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний зүйл заалтуудтай танилцахад мэргэжлийн түвшинд сайн боловсрогдоогүй, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой томъёолоогүй, бүр хөрөнгө оруулагч талд ая тал зассан олон улсын гэрээ, хэлцэлд тэр бүр тохиолддоггүй “боломжтой бол”, “нааштайгаар авч үзнэ”, “хүчин чармайлт гаргана” зэрэг зүйлүүд олон байгаа нь ажиглагддаг. Гэвч энэхүү хөрөнгө оруулалтын гэрээ нь хөдлөшгүй зүйл биш юм. Гэрээ, хэлцлүүдийг хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт, нэмэлтийг оруулах боломжтой.

Оюу толгойн хувьд дээр дурдсан сөрөг туршлагаудыг эерэг болгох үүднээс хөрөнгө оруулагчтай гэрээний холбогдох заалтад өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд нь тавих хяналтыг сайжруулах, менежментийн багт монголын талын хүмүүсийг хувьцааны хувь хэмжээгээр оруулж ажиллуулах, уул уурхайн томоохон төслийн хэлэлцээ хийх мэргэжлийн багийг үндэсний хэмжээнд бүрдүүлэх, төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг томоохон зорилтуудыг шийдвэрлэх нь зүйтэй байна.